

**АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХЭЛТЭС, СУМД БОЛОН АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРЫН
2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН**

Т А Й Л А Н

2010.01.20.

Дархан-Уул аймаг

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн бүтцэд “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг”-тай байхаар тогтоосны дагуу Тамгын газрын даргын 2009 оны 11 дүгээр тушаалаар 4 орон тоотойгоор ХШҮ-ний тасаг шинээр байгуулагдан ЗГХЭГ-аас өгсөн ерөнхий чиг үүрэг болон “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг үнэлэх замаар сум, агентлагуудын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлөгөө дэмжлэгээр цаг тухайд нь хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжтэй хамтран ажиллах замаар хэрэгжүүлж ажиллалаа.

Тус тасаг нь 2009 онд аймаг, сумдын ЗДТГ, агентлагуудын ХШҮ-ний асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн дунд нэгдсэн сургалт семинарыг зохион байгуулж, энэ сургалтад нийт 50 гаруй албан хаагч хамрагдаж, тэднийг гарын авлага материалаар хангаж ажиллалаа. Аймгийн хэмжээд одоогийн байдлаар 4 сум, 20 агентлагын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний 24 багийн 80 гаруй мэргэжилтэн ажиллаж байна.

ХШҮ-ний тасаг нь аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргын баталсан “ХШҮ-гээ хийх хуваарь”, “Удирдамж”-ийн дагуу 2 сум, 10 агентлагийн дарга нарын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын бодлого, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байгаатай газар дээр нь очиж танилцан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үр дүнд 15 арга хэмжээ бүхий “Зөвлөмж” боловсруулан бүх сум, агентлагуудад хүргүүлж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

2009 оны жилийн эцсийн байдлаар Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийт 63 үзүүлэлтийн ерөнхий үнэлгээ 4.70, үүнээс эдийн засгийн хөгжлийн 27 үзүүлэлт 4.56, нийгмийн 19 үзүүлэлт 4.75, хөгжлийн 17 үзүүлэлт 4.77 оноотой гарсан байна. **“Аймгийн 2009 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үнэлгээ”-г хавсаргав.**

Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлагын дарга нарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, ХШҮ-ний тасаг бүрэн бүрэлдэхүүнээрээ, сум, агентлагийн дарга, тухайн байгууллагын ХШҮ-ний багийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй 3 байгууллагын төлөөлөгч оролцож, хэлтэс, сум, агентлаг бүрийн 2009 оны үйл ажиллагааны үр дүнг:

1. Бодлогын 10 баримт бичиг
 - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
 - Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
 - МУ-ын нийгэм, эдийн засгийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл,
 - Аймгийн нийгэм, эдийн засгийг 2009 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт
 - Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр
 - МУ-ын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан “Батламж”
 - Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
 - Үндэсний хөтөлбөр,
 - ТАХ-ийн “Үр дүнгийн гэрээ”
 - ТЕЗ-аас бүх шатны Ерөнхий менежерүүдтэй байгуулсан “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”
2. Хурлын ирц, мэдээ, тайлан хугацаандаа ирүүлсэн байдал, боловсруулалтын чанар, **/АЗДЗХуралдаан, Агентлагын дарга нарын хурал, УАЗ/**
3. Хэрэглэгчийн үнэлгээ,
4. Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт,
5. Аймгийн Засаг даргын захирамж, Албан даалгавар,
6. Сарын мэдээ,
7. “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээ зохион байгуулсан байдал,
8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаас боловсруулан гаргасан “Зөвлөмж” зэргийг үндэслэн дүгнэлээ.

Аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, Цэргийн штаб, 4 сум, 20 агентлагын дарга нарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба аймгийн нэгдсэн дүнгээр 90.0% буюу 4.50 оноотой, үүнээс хэлтсийн дүнгээр 93.0% буюу 4.65 оноо, сумдын дүнгээр 84.2,% буюу 4.21 оноо, агентлагийн дүнгээр 91.83% буюу 4.59 оноогоор тус тус дүгнэгдсэн байна.

“Үр дүнгийн гэрээ”, “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”-г дүгнэсэн үнэлгээгээр аймгийн хэмжээнд 2008 онд 22 байгууллагын дундаж үнэлгээ 88.9% буюу 4.44 оноогоор үнэлэгдсэн бол 2009 онд 24 байгууллагын дундаж үнэлгээ 90.3% буюу 4.51 оноогоор үнэлэгдэж, нийт 15 байгууллагын үзүүлэлтэд тодорхой ахиц гарсан нь явцын үнэлгээ хийж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгсөн, хэлтэс, сум, агентлагийн жилийн эцсийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж дүгнэсэн нь Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг нь ерөнхий чиг үүрэг, батлагдсан дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулсны үр дүн болно.

Төсвийн Ерөнхийлөн захирагч /аймгийн Засаг дарга/ болон Ерөнхий менежер /агентлагуудын дарга нар/-ийн хооронд байгуулсан “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”, “Менежерийн үр дүнгийн гэрээ”-ний биелэлтийг 2009 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 сум, 24 агентлаг */Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор тогтоосон 20 агентлаг/* мэдээ, ирүүлэхээс **Шарын гол, Хонгор сум,**

ХХҮХ хугацаандаа ирүүлээгүй, Захирагчийн алба, Гаалийн алба, Тагнуулын хэлтэс, мөн УБХ шинээр байгуулагдсан, эдгээр 4 агентлаг аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй учраас ХШҮ хийгдээгүй. Хугацаандаа мэдээ, тайлангаа ирүүлсэн 2 сум, 17 агентлаг болон УЦУБОША, ШША-ны гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, агентлаг нэг бүрээр дүгнэлт гаргалаа.

Үнэлгээг сум, агентлагийн байдлаар танилцуулахад :

- Хурлын ирц, мэдээ, тайлангийн ирүүлсэн байдлаар сумдаас Дархан сум – 93.8% буюу 4.69 оноо, агентлагуудаас Татварын хэлтэс, НДХ – 100% буюу 5.00 оноо, ХХААЖДҮГ – 99.3% буюу 4.96 оноо, ОБГ – 98.4% буюу 4.92 оноогоор **“А”** буюу **“Маш сайн”** гэсэн үнэлгээгээр үнэлэгдсэн бол **хурал, зөвлөлгөөн удаа дараа тасалсан, мэдээ, тайлангаа хугацаандаа ирүүлээгүй** Шарын гол сум - 55.0% буюу 2.75 оноогоор **“Е”** буюу **“Хангалтгүй”** гэсэн үнэлгээгээр, Хонгор сум – 70.8% буюу 3.50 оноо, ГХБХБГ – 73.3% буюу 3.66 оноо, СХЗХ – 79.7% буюу 3.98 оноогоор **“С”** буюу **“Хангалттай”** гэсэн үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн байна.
- “Менежерийн үр дүнгийн гэрээ”, “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”-ний хэрэгжилтээр сумдаас Дархан сум – 97.6% буюу 4.88 оноо, Орхон сум – 90.0% буюу 4.50 оноо, агентлагуудаас ХХААЖДҮГ – 98.1% буюу 4.90 оноо, Татварын хэлтэс, Цагдаагийн газар – 97.0% буюу 4.85 оноо, НААҮГ, Статистикийн хэлтэс, ОБГ, ГХБХБГ – 95.0% буюу 4.75 оноо, Эрүүл мэндийн газар, МХГ – 90.0% буюу 4.50 оноогоор **“А”** буюу **“Маш сайн”** гэсэн үнэлгээгээр үнэлэгдсэн бол Хонгор, Шарын гол сум 80.0% буюу 4.00 оноо, БОАЖГ – 88,0% буюу 4.40 оноогоор **“В”** буюу **“Сайн”** гэсэн үнэлгээгээр, ХХҮХ – 70.0% буюу 3.50 оноогоор **“С”** буюу **“Хангалттай”** гэсэн үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт дүнгээр Татварын хэлтэс – 96.6% буюу 4.83 оноо, ХХААЖДҮГ – 94.7% буюу 4.74 оноо, ХТХ, НДХ – 94.2% буюу 4.71 оноо, ЭМГ – 94.1% буюу 4.70 оноо, Цагдаагийн газар 94.0% буюу 4.70 оноогоор **“А”** буюу **“Маш сайн”** гэсэн үнэлгээгээр үнэлэгдсэн бол ХХҮХ – 89.1% буюу 4.54 оноо, БОАЖГ – 88.5% буюу 4.42 оноо, МХГ – 88.2% буюу 4.41 оноо, ГХБХБГ – 86.3% буюу 4.31 оноо, БТСГ – 85.3% буюу 4.26 оноогоор **“В”** буюу **“Сайн”** гэсэн үнэлгээгээр тус тус дүгнэгдлээ.

Сум, агентлагуудын 2009 оны жилийн эцсийн ажлыг дүгнэхэд ХШҮ-ний тасгаас гаргасан “Зөвлөмж”-д тусгагдсан арга хэмжээнүүдээс бодлогыг хэрэгжих үеэс нь эхлэн хэрэгжиж дуусах хүртэл хугацаанд ямар үр дүнд хүрсэн, амжилт, алдаа оноо, хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ төрийн бус байгууллагын төлөөллийг хэрхэн оролцуулсан байдал, бичиг баримтын боловсруулалтын чанар ямар түвшинд хийгдсэн, ТАХ бүр хариуцан гүйцэтгэж буй ажилдаа хэрхэн хандсан, хэлтэс, агентлаг бүр өөрийн байгууллагын онцлогт тохирсон үндсэн шалгуур үзүүлэлт гаргасан зэрэг заалтуудыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар бид авч үзсэн. Гол нь ямар зорилт дэвшүүлж, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрсэн бэ? гэдэгт онцгой анхаарал хандуулсан.

“Зөвлөмж”-д тусгагдсан 1 чухал арга хэмжээ болох байгууллага бүр өөрийн онцлогт тохирсон шалгуур үзүүлэлт гаргах тал дээр онцгой анхаарч ажилласан байдлыг авч үзсэн. Тухайлбал: Татварын хэлтэс жилийн үйл ажиллагааны үр дүнгээ 28 шалгуур үзүүлэлт, 43 заалтаар, Статистикийн хэлтэс 8 шалгуур үзүүлэлт, 35 заалтаар 918 оноогоор 100%-иар дүгнэсэн байна. Иймд эдгээр байгууллагын тэргүүн туршлагыг бусад сум, агентлагууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай.

ХШҮ-гээ хийх явцад илэрсэн нийтлэг дараахь давуу тал буюу амжилт бүтээл, сул тал буюу зөрчил дутагдлууд байна. Үүнд :

А. Давуу тал /шинэлэг ажлууд/:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар тодорхой ахиц гарсан;
2. Ямар зорилт дэвшүүлсэн, ямар үр дүнд хүрэхээ ойлгосон;
3. Тухай жилд хийсэн үйл ажиллагааныхаа ололт, амжилтыг тодорхойлох, олж тогтоох эхлэл тавигдаж байна;
4. Хянал-шинжилгээний явцын үнэлгээ хийсэн сум, агентлагуудын ажил тодорхой хэмжээгээр сайжирсан байна, явцын үнэлгээ хийгээгүй байгууллагуудаас ялгаа нь эрс ажиглагдаж байна;
5. Зарим агентлагууд тухайн онд хийсэн бүтээлч, шинэлэг ажлуудаа тодорхойлж үр дүнгээ гаргасан байна, тухайлбал Татварын хэлтэс 3-5, БСГазар 13 ажил шинээр хийсэн байна;
6. Бүх сум, агентлагууд ХШҮ-ний талаар нэгдсэн ойлголтод хүрсэн байна;
7. Сум, агентлагууд юу хийсэн, ямар амжилтад хүрсэн, газар дээр нь очиж үзээч гэсэн шаардлага тавих зэрэг өөрсдийн тухайн жилд хийсэн ажлын талаарх мэдээллээ ойлгуулах, тайлбарлах гэж оролдож эхэлж байна. /НДХ, БСГ, Хонгор, Шарын гол сум/;
8. Зарим байгууллага шалгуур үзүүлэлтээр ажлаа дүгнэсэн байна /Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс/;
9. Урсгалаараа явдаг хуучин сэтгэлгээнд тодорхой өөрчлөлт орж, байгууллага бүр хийсэн ажилтай, хэлэх үгтэй болох талаар мэрийх, чармайх оролдлого гарч эхэлж байна.

2. Сул тал /Зөрчил дутагдлууд/:

1. Мэргэшсэн төрийн албан хаагчийг ажлаас нь чөлөөлөх, халах, солих,**(Шарын гол сум, Хонгор сум)**;
2. ХШҮ хийх үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар гаргасан “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажил маш хангалтгүй **/Бүх сум, агентлагуудын дарга нар/**;
3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн заалт нэг бүр дээр үнэлгээ огт хийгдээгүй, эсвэл буруу үнэлсэн, ерөнхий үнэлгээ буруу дүгнэгддэг;
4. Оны эхнээс баталж өгсөн хуваарьт тусгагдсан мэдээ, тайлан ирүүлэх хугацааг хоцроосон **/Шарын гол, Хонгор сум, /**;
5. Баримт бичгийн боловсруулалт, хэл найруулгын алдаатай, тоон үзүүлэлт дутуу, хангалтгүй;

6. Өөриймсөг сэтгэл дутмаг, хариуцсан ажилдаа эзэн болохгүй, “Үр дүнгийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлдэг¹;
7. Байгууллага бүрийн ХШҮ-ний баг хангалтгүй ажиллаж байна;
8. Мэдээ, тайлан хугацаа хоцроосон, баримт бичгийн боловсруулалт хангалтгүй, “Зөвлөмж”-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлээгүй мэргэжилтнүүдтэйгээ, ялангуяа төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг гардан зохион байгуулдаг, мэдээ, тайланг хариуцан боловсруулан гаргаж байгаа нэгжийн мэргэжилтэнтэйгээ сум, агентлагийн дарга нар ажлын хариуцлага тооцож ажиллах;
9. ХШҮ-ний талаарх мэдлэг, ур чадвар хангалтгүй байна.

ХШҮ-ний тасгийн нь хэлтэс, сум, агентлагын үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу явагдсан, дүгнэгдсэн, үнэлэгдсэн, иргэдэд хийсэн ажлаа үнэн зөв, бодитой тайлагнасан, сурталчилсан, мэдээлсэн, тэдний сайн сайхны төлөө төрийн үйлчилгээгээ үзүүлсэн зэрэг тал дээр л мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх, залж чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр ажиллалаа.

ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД:

1. Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлаг мэдээ, тайлангаа ирүүлэхдээ заавал тухайн байгууллагын даргаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх (*Баталгаажуулаагүй мэдээ, тайланг хүлээж авахгүй, дүгнээгдэхгүй*);
2. Мэдээ, тайланг хугацаандаа ирүүлэх, (*1 хоног хоцорсон бол үнэлгээ буурна*);
3. ХШҮ-ний тасгаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар боловсруулж гаргасан “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хэрэгжүүлэх;
4. Сум, агентлаг бүр ХШҮ-ний багаа сайн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх, улирал, жилийн мэдээ, тайланд баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ХШҮ-гээ хийж, баталгаажуулан ирүүлж байх;
5. ХШҮ-ний багийн мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэгийг байнга дээшлүүлэх;
6. Бодлогын хэрэгжилт, үр дүнд шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг хөгжүүлэх;
7. Хэлтэс, сум, агентлаг бүр үйл ажиллагааны үр дүнд “Ногоон карт – шалгуур үзүүлэлт”-ын үйлчилгээг нэвтрүүлэх;

¹ (“... зарим төрийн албан хаагчид ажилдаа чин сэтгэлээр хандаж, бүх нөөц бололцоогоо дайчлан олон түмний төлөө зүтгэх сэтгэл дутаж, цаг нөхцөөх, чадвар, мэдлэгээр маруухан мөртлөө биеийн амрыг харан суух, хэн нэгэн өндөр албан тушаалтны нөмөр, нөөлөгт хорогдож цалингийн манаачийн үүрэг гүйцэтгэх явдал байсаар байна.” 2008.12.16-ны өдөр МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга “Төрийн албан хаагчидтай уулзаж хэлсэн үгнээс”

8. “Менежерийн үр дүнгийн гэрээ”, “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”-ний тайлагнах тал дээр онцгой анхаарч ажиллах;
9. Хэрэглэгчийн үнэлгээг иргэд, ТББ-ын оролцоо, дэмжлэгтэйгээр хийж, улирал бүр ирүүлж байх.

Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлагын дарга нарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгдсэн дүнг 2010.01.20-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, “**Хангалттай**” гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагуудын хурал дээр ХШҮ-ний нэгдсэн дүнгийн талаар агентлаг тус бүрээр дэлгэрэнгүй танилцуулж, цаашид анхаарч ажиллах талаар аймгийн Засаг дарга үүрэг даалгавар өглөө.

Аймгийн Засаг даргын 2010 оны 26, 27 дугаар захирамжаар хэлтэс, сум, агентлагийн дарга нарын 2009 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ дүнгээр “**Маш сайн**” гэж үнэлэгдсэн 1 сум, 5 агентлагийн дарга нарыг албан тушаалын 1 сарын үндсэн цалингаар шагнаж урамшуулж, “**Хангалтгүй үнэлгээ**” авсан 2 сум, 6 агентлагийн дарга нарт цалин бууруулах, сануулгийн шийтгэл ногдуулах зэрэг хариуцлагын арга хэмжээ авлаа.

”Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнд шинжилгээ, судалгаа хийж, цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг боловсронгуй болгох талаа “Зөвлөмж” боловсруулан бүх сум, агентлагуудад хүргүүллээ.

ХЯНАСАН :

ТЗУХ-ИЙН ДАРГА

Б. АРЪЯА

Т А Й Л А Н Б О Л О В С Р У У Л С А Н :

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСГИЙН

ДАРГА

Д . Ж А Р Г А Л С А Й Х А Н

ХШҮ-НИЙ МЭРГЭЖИЛТЭН

Н. МӨНХБАЯР

Н. НАРАНГЭРЭЛ

О. БУЯНАА